



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А162

Бор-Өндөр сум

**Өмчлөлийн газрын хэмжээ өөрчлөлтийн
зөрүүг арилгах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 267 дугаар “Геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоог шинэчлэн батлах тухай” тогтоол, “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажлын хүрээнд Бор-Өндөр сумын эзэмшил, өмчлөлийн газарт хийсэн хяналтын хэмжилтээр одоо байгаа нэгж талбарууд хэмжээний зөрүүтэй байсан бөгөөд уг зөрчлийг арилгах зорилгоор хавсралтад дурдсан 2 иргэнд 1474 мкв газрын хэмжээг залруулж өмчлүүлсүгэй.

2.Энэхүү захирамж гарсантай холбоотой нэгдүгээр хавсралтад дурдсан өмнөх захирамжийн холбогдох хэсгүүдийг хүчингүй болсонд тооцсугай.


3.Холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд өмчлөх эрхээ хэрэгжүүлэхийг газар өмчлөгчдөд, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (З.Ууганжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ


Сумын Засаг даргын 2026 оны 03-р сарын 11-ны өдрийн 119р захирамжийн нэгдүгээр хавсралт



Газар өмчлөгч иргэдийн мэдээлэл

Д/д	Өмчлөгчийн			Хамтран өмчлөгчийн			Өмнөх захирамжийн				
	Ургийн овог	Эцэг эхийн нэр	Нэр	Регистр	Эцэг эхийн нэр	Нэр	Регистр	Огноо	Дугаар	Хавсралтын дугаар	Холбогдох хэсгийн дугаар
1	Хотгойд	Наваан	Ваанчиг	СШ51110119	Батсүх	Аюурзана	СК75052500	2014.08.29	153	1	1
2	Тоот	Бадарч	Гантулга	СШ68022917	Гантулга	Ариунбаяр	СШ98080411	2008.02.25	27	1	8
					Гантулга	Ариун-Эрдэнэ	СШ03301406				

Сумын Засаг даргын 2026 оны 8-р сарын 11-ны өдрийн 1180 захирамжийн нэгдүгээр хавсралт



Үргэлжлэл

д/д	Өмнөх газрын		Хэмжээ	Байршил	Ашиглалтын зориулалт	Үнэ /төгрөг/
	Нэгж талбарын дугаар	Гэрчилгээнд бичигдсэн хэмжээ				
0	12		15	16	17	18
1	2318010285	908	911	3-р баг Бумбат, Хангай-7 гудамж, 708 тоот	Гэр бүлийн хэрэгцээ	2733000
2	221000883	561	563	4-р баг Уурхайчин, Геологи-16 гудамж, 1604 тоот	Гэр бүлийн хэрэгцээ	1689000
Нийт			1474			4422000